



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/394

Есөнбулаг сум

Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй
зээлийн эргэн төлөлтийг сайжруулах, авлагыг
барагдуулах аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Засгийн газрын Тусгай сангийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5, 25 зүйлийн 25.4, 25.6 дахь хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2026 оны 04 дугаар сарын 23-ны өдрийн А/167 дугаар тушаал, 2026 оны 05 сарын 08-ны өдрийн А/190 албан даалгавар, Жижиг дунд үйлдвэрийн газрын даргын 2026 оны А/85 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлтийг сайжруулах, авлагыг барагдуулах аяныг 7 дугаар сарын 22-ны өдрөөс 9 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл зохион байгуулсугай.

2.Аяны үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, хяналт хийх ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, сумдад ажиллах хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Хоршоо хөгжүүлэх сангийн өр авлагыг барагдуулах аян, хоршоо хөгжүүлэх сангийн улсын үзлэг, хоршоодын хөгжлийн үнэлгээг аргачлалын дагуу зохион байгуулж, тайланг Жижиг дунд үйлдвэрийн газарт 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлэхийг ажлын хэсэг (Ж.Очир)-т үүрэг болгосугай.

4.Шаардагдах зардал 1,120,000 (нэг сая нэг зуун хорин мянган) төгрөгийг хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (М.Насанбат)-т зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс (Д.Чинзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны
09 дугаар сарын 22 ны өдрийн // дүгээр
захирамжийн нэгдүгээр хавсралт

Ажлын хэсэг:	Ж.Очир	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
	Р.Цэнд-Аюуш	(аймгийн Засаг даргын Тамгын газрын Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ ЖДҮ-ийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)
	С.Эрдэнэ-Очир	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн хэлтсийн дарга)
	Б.Пүрэвжав	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын Захиргаа удирдлагын хэлтсийн дарга)
	А.Сувданчимэг	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хяналтын хэлтсийн дарга)
	П.Мөнхзаяа	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнс, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)
	Х.Нордогбат	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын Газар тариалангийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)
	Т.Галсан	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын нягтлан бодогч)
Нарийн бичиг	Б.Чимэгбаяр	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйлдвэрлэл, хоршоо, ахуйн үйлчилгээний хэлтсийн дарга) Сумдын засаг дарга нар

Аймгийн Засаг даргын 2026 оны
07 дугаар сарын 4-ны өдрийн 1 дүгээр
захирамжийн хоёрдугаар хавсралт

СУМДАД АЖИЛЛАХ ХУВААРЬ

Д/д	Сум	Хугацаа
1	Тайшир	7 сарын 28-30
2	Дэлгэр	7 сарын 28-30
3	Тонхил	8 сарын 3-7
4	Дарви	8 сарын 3-7
5	БаянУул	8 сарын 3-7
6	Хөхморьт	8 сарын 3-7
7	Жаргалан	8 сарын 3-7
8	Эрдэнэ	8 сарын 10-14
9	Чандмань	8 сарын 10-14
10	Цогт	8 сарын 10-14
11	Бигэр	8 сарын 10-14
12	Халиун	8 сарын 10-14
13	Шарга	8 сарын 17-21
14	Төгрөг	8 сарын 17-21
15	Цээл	8 сарын 17-21
16	Алтай	8 сарын 17-21
17	Бугат	8 сарын 17-21
18	Есөнбулаг	8 сарын 24-28

_ оОо _



پس منہ پر پھینک دیا۔ یہاں پر - یہاں پر پھینک دیا۔
پس منہ پر پھینک دیا۔ یہاں پر - یہاں پر پھینک دیا۔

الدراسات والبحوث

فصل پنجم در بیان احوال و عیال و معاش و غیره

[illegible][illegible]

۷ .. یکم و پنجیم یخچیس، د یختتم لمړی وختیکو ، لسیزې زده کړه مه ترسره
کولای شئ . پرمه به یخچیس وروسته د یکتا شپږمه او نه مه کورنۍ

[illegible][illegible][illegible]

نام : عسرويه

فرضه منحصراً

[illegible]

00000000000000000000